


Батлав."УБДС"ТӨХК-ий Ерөнхий инженер



..... Б.Батбаяр

**“Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн эрчим хүчний хэмнэлтийн
аудит хийх ажлын даалгавар**

Улаанбаатар хот

2019 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр

Дулаан хангамжийн талаар:

1. Дамжуулах сүлжээний нийт алдагдал, үүнээс техникийн болон арилжааны алдагдлыг ижил технологтой бусад орнуудын алдагдалтай харьцуулан дүгнэлт хийх.
2. Компанийн эзэмшлийн ил болон далд /312км/ шугамын гадаргуугийн бодит алдагдлыг оновчтой тодорхойлох аргачлал боловсруулан, тодорхойлж тайлан гаргаж өгөх.
3. Компанийн хэмжээнд ашиглагдаж байгаа дулааны шугамын дулаан тусгаарлах материалуудын дулаан дамжуулалтын /дулааны алдагдлын/ коэффициентын бодит туршилтыг оргил ачааллын үед хийж, материал тус бүр дээр дүгнэлт гаргаж өгөх.
4. Компанийн дамжуулах сүлжээний нэмэлт усны алдагдалын шалтгааныг тодорхойлох, бууруулах боломжийн судалгаа, тайлан гаргаж өгөх.
5. Компанид ашиглагдаж байгаа тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, засвар шинэчлэлтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх.
6. Дамжуулах сүлжээний дулаан түгээлтийн алдагдлыг бууруулах талаар хэрэгжүүлэх хөтөлбөрийн санал гаргаж өгөх.
7. Төвлөрсөн дулаан хангамжийн түгээх сүлжээ буюу хоёр дугаар хэлхээний температурын графикийн оновчтой хувилбарыг тооцож үйлдвэрлэлд нэвтрүүлэх.

Цахилгаан хангамжийн талаар:

8. Компанийн насос станцуудын цахилгаан тоноглол, хөдөлгүүр, трансформаторуудыг ашигт үйлийн коэффициент өндөртэй, цахилгаан

эрчим хүчний хэмнэлттэй орчин үеийн тноголлоор солих талаар тодорхой тооцоо хийж зөвлөмж өгөх.

9. Компанийн оффиссын барилга, насос станцууд, оффисс, автограж, өргөтгөлийн барилгуудын дотоод хэрэглээний ус, дулаан, цахилгааны хэрэглээнд аудит хийж дүгнэлт зөвлөмж гаргана.

Бусад

10. Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай компанийн эрчим хүчний хэмнэлтийн бодлогын баримт бичиг боловсруулахад зөвлөмж бэлтгэн өгөх, орчин үеийн эрчим хүчний хэмнэлттэй шинэ техник технологи, гадаад болон дотоод түгээх, дамжуулах сүлжээний давуу тал туршлагын талаар зөвлөмж өгөх.
11. “Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ний эрчим хүчний ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх талаар мэдээлэл суртчилгааны материал, эрчим хүчний менежментийн ISO-50001 стандартыг нэвтрүүлэх талаар зөвлөмж бэлтгэж өгөх.
12. Хийсэн тооцоо судалгаа, хөтөлбөр, зөвлөмж, нэгтгэсэн ажлын тайланг ерөнхий инженер болон хэмнэлтийн менежерээр гарын үсэг зуруулж, бичгээр болон файлаар хүлээлгэн өгч акт үйлдэнэ.

Хянасан: ТБХ-н дарга



Ш.Мөнхжаргал. 2

ГТА-н дарга

Т.Алтангарэл

ТЭЗХ-н дарга



Х.Эрдэнэчулуун

Боловсруулсан: ТБХ-н хэмнэлтийн менежер



Б.Баярмаа